



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/609

Номгон

Сумдын Онцгой комисс, өвөлжилтийн  
бэлтгэл ажлыг шалгах Шуурхай бүлэг  
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын “а”, 29.1.6-ын “а”, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27<sup>1</sup>.1.6, 27<sup>1</sup>.2, , 27<sup>1</sup>.3, , 27<sup>1</sup>.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2021 оны “Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах тухай” 221 дүгээр тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны “Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг эрчимжүүлэх тухай” 01 дүгээр албан даалгавар, аймгийн Засаг даргын 2021 оны А/526, А/536 дугаар захирамж, аймгийн Засаг даргын 2021 оны “Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл хангах тухай” 03 дугаар албан даалгавар, аймгийн Онцгой комиссын 2021 оны 66 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймагт голомтлон гарсан коронавирусын халдвар болон мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний голомтыг барих, тархалтыг бууруулах, мөн цаг агаарын урьдчилсан төлөвөөр ирэх өвөл хур тунадас ихтэй, агаарын температур олон жилийн дунджаас хүйтэн байж өвөлжилт, хаваржилт хүндрэх эрсдэл үүсч болзошгүй байгаа тул хангай, говь чиглэлд дээрх нөхцөл байдлыг үнэлэх, бэлтгэл ажлыг шалгах, хяналт тавих үүрэг бүхий аймгийн Онцгой комиссын Шуурхай бүлгүүдийг томилсугай.

2. Шуурхай бүлгийн гишүүдийг нэгдүгээр, хяналт шалгалтын үйл ажиллагааны удирдамжийг хоёрдугаар, шаардагдах зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хяналт шалгалтын үйл ажиллагааны зардал **2,858,200** (Хоёр сая найман зуун тавин найман мянга хоёр зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.


601210421

2.

4. Сумдын Онцгой комиссын үйл ажиллагааг чиглүүлж, удирдамжийн хэрэгжилтийг хангаж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдөр аймгийн Онцгой комиссын хуралд танилцуулахыг ажлын хэсэг дарга нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой комиссын орлогч дарга, Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2021 оны  
09 дүгээр сарын 29 ны өдрийн  
1609 захирамжийн 1 дүгээр  
хавсралт

## АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ШУУРХАЙ БҮЛГИЙН ГИШҮҮД

### 1 дүгээр чиглэл: Говь

Өлзийт, Жинст, Богд, Баянлиг, Баянговь, Шинэжинст, Баян-Өндөр,  
Баянцагаан, Баацагаан, нийт 9 сум хамаарна.

Шуурхай бүлгийн ахлагч:

1. Б.Батсуурь

Аймгийн Засаг даргын орлогч,

Гишүүд:

2. М.Төмөрчөдөр

Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын  
хяналтын байцаагч, дэслэгч,

3. М.Дүгэрмаа

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн  
бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн бодлогын  
асуудал хариуцсан мэргэжилтэн,  
Сум дундын ойн ангийн дарга,

4. Т.Уртнасан

Нарийн бичиг:

5. С.Тэгшбаяр

Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны  
дарга

Жолооч:

6. Э.Энэбиш

Аймгийн Засаг даргын Тамгын газар жолооч

### 2 дугаар чиглэл: Хангай

Бөмбөгөр, Бууцагаан, Хүрээмарал, Баянбулаг, Гурванбулаг, Заг,  
Жаргалант, Галуут, Баян-Овоо, Эрдэнэцогт, Баянхонгор, нийт 11 сум хамаарна.

Ажлын хэсгийн ахлагч:

1. Т.Хишигбаатар

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө  
оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн  
хэлтсийн даргын албан үүргийг түр орлон  
гүйцэтгэгч,

Гишүүд:

2. Б.Пүрэвдорж

Онцгой байдлын газрын Бууцагаан сум дахь Гал  
түймэр унтраах, аврах 72 дугаар ангийн захирагч,  
ахлах дэслэгч,

3. Б.Наранбаяр

Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн  
бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга,

4. А.Нямхүү

Нарийн бичиг:

5. Ж.Баасансүрэн

Хүнс, хөдөө аж ахуйн газрын Бэлчээр, тэжээл, усан  
хангамж хариуцсан мэргэжилтэн,


Жолооч:

6. Т.Мөнхбаатар

Аймгийн Засаг даргын Тамгын газар жолооч

oOo

Аймгийн Засаг даргын \_\_\_\_\_ оны  
09 дүгээр сарын 29 ны өдрийн  
1/609 захирамжийн 2 дугаар  
хавсралт



## АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ШУУРХАЙ БҮЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

### Нэг. Зорилго

Тус аймагт голомтлон гарсан коронавирусын халдвар болон мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний голомтыг барих, тархалтыг хүйтний улирал ирэхээс өмнө бууруулах, мөн мэргэжлийн байгууллагуудаас ирүүлсэн цаг агаарын урьдчилсан мэдээллээр ирэх өвөл хур тунадас ихтэй, агаарын температур олон жилийн дунджаас хүйтэн төлөвтэй байгаа бөгөөд өвөлжилт, хаваржилт хүндрэх эрсдэл үүсч болзошгүй байгаа тул хангай, говь чиглэлд дээрх нөхцөл байдлыг үнэлэх, бэлтгэл ажлыг шалгах, хяналт тавих, мэргэжлийн удирдлага, зохицуулалтаар хангах.

### Хоёр. Хугацаа, хамрах хүрээ

2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл, нийт 10 хоногийн хугацаанд 20 сум болон холбогдох байгууллагуудыг хамруулан зохион байгуулна.

### Гурав. Хяналтын үйл ажиллагааны чиглэл:

1. Сумдын Онцгой комиссын үйл ажиллагаатай танилцах, 24 цагаар гарч байгаа Шуурхай штабын бэлтгэх бэлэн байдлыг шалгах, үзлэг хийх, сумдын Засаг даргын нөөцийн захиран зарцуулалтыг шалгах, (0-10 оноо)
2. Хөдөө аж ахуйн болон төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл шалгах, нөхцөл байдалтай танилцаж газар дээр нь заавар чиглэл өгөх, дутагдлыг арилгуулах, хугацаатай даалгавар өгөх, (0-10 оноо)
3. Сумын аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийг бүрдүүлэлтийг шалгах, нэг бүрчлэн үзлэг хийх, (0-10 оноо)
4. Өвөлжилтийн бэлтгэл хангах, өвөлжилт хаваржилтыг даван туулах талаар сум орон нутгийн авч хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээтэй танилцах, төлөвлөлт, түүний хэрэгжилтийг шалгах, (0-10 оноо)

2.

5. Төв суурин газрын байгууллага, аж ахуй нэгж, айл өрхийн түлээ түлшний бэлтгэл, нөөц, цахилгаан эрчим хүч, сан техникийн үйл ажиллагааны аюулгүй байдалд үзлэг шалгалт хийх, (0-10 оноо)

6. Улс, орон нутгийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалт, урсгал болон их засварын ажлын явцыг шалгах, (0-10 оноо)

7. 2020-2021 онд аймгийн аюулгүйн нөөцөөс сумдад олгосон өвс, тэжээлийн өр, авлагыг барагдуулах, (0-10 оноо)

8. Малын гоц халдварт Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, хорио цээрийн дэглэмийн хэрэгжилтийг шалгах, мал эмнэлгийн нэгжүүдийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулах, Онцгой комиссын харилцан ажиллагааг сайжруулах, (0-10 оноо)

10. Эрүүл мэндийн төв, эмнэлгийн байгууллагуудын тусламж үйлчилгээний бэлэн байдал, нөөцтэй танилцах (0-10 оноо)

11. Сумын Онцгой комиссын хурлыг 2 удаа (эхлэл болон төгсгөлд) зохион байгуулж, үнэлгээ дүгнэлтийг газар дээр нь өгч, санал шүүмжийг албан бичгээр авах,

Үнэлгээний хуудас: Загвар

Сумдын нэр: .....


д/д	Хяналтын үйл ажиллагааны чиглэл	Оноо	Тайлбар
1			
2			
3			
10			
-	Нийт дүн	0-100	

**Дөрөв. Дүгнэлт**

Тухайн сумын үнэлгээ, дүгнэлтийг шалган зааварчилсан ажлын үр дүн, бэлтгэл ажлыг дүн, бичиг баримтын бүрдэл, дээд шатны байгууллагын үүргийн хэрэгжилтийг үнэлэмжийг тус тус үндэслэн ажлыг хэсэг нэгдсэн дүгнэлт гаргаж, тухайн сумын Онцгой комиссын хуралд танилцуулна.

.....оОо.....

Аймгийн Засаг даргын \_\_\_\_\_ оны  
 09 дугаар сарын 09 ны өдрийн  
 17009 захирамжийн 3 дугаар  
 хавсралт



### ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Нэг. Хоол, хүнс							
Д/д	Хүний тоо	Хоолний нэг бүрийн үнэ	Өдөрт нэг хүн	Хоног	Нийт дүн (төг)	Хянасан	
1	12	5000 төг	3 удаа	10	1.800.000		
Хоёр. Шатахуун							
Д/д	Тээврийн хэрэгсэл	Явах зай (км)	Автомашинны норм	Нийт шатахуун	Нэг бүрийн үнэ	Нийт дүн (төг)	
1	Lexus-470	1000 км /сул.яв-100 км/	20 литр	200 литр	2860 төг	572,000	
2	Lexus-470	850км /сул.яв-110 км/	20 литр	170 литр	2860 төг	486,200	
3	Lexus-470	1850км	20 литр	320 литр	2860 төг	1,058,200	
Гурав. Зардлын нэгдсэн дүн							
1	Хоол				1.800.000		
2	Шатахуун				1,058,200		
3	Нийлбэр дүн				2,858,200		

oOo